

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлийн
2014 оны ажлын ТАЙЛАН

2014,12,30

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөл нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 08 дугаар сарын 14-ны өдрийн А/130 дугаар тогтоолоор анх байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн юм

Тус зөвлөл нь үйл ажиллагаандаа Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль болон Хууль зүйн сайдын 2014 оны А/ 89 дүгээр тушаалаар баталсан Иргэний зөвлөлийн дүрмийг мөрдлөгө болгон ажиллаж ирлээ.

Тус зөвлөл нь анхныхаа хуралдааныг 2014 оны 08 дугаар сарын 20 – нд хийж Иргэний зөвлөлийн дарга сонгох асуудал хэлэлцэж даргаар Н. Гэжээг сонгож баталлаа.

Иргэний зөвлөл хоёр дахь ээлжит бус хуралдаанаа 2014 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр хийж Хууль зүйн сайдын 2014 оны А/89 дүгээр тушаалаар баталсан Иргэний зөвлөлийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4-10 дахь заалтыг баримтлан аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлийн хуралдааны дэгийн төслийг боловсруулан хуралдаанаар оруулан хэлэлцүүлж гишүүдийн саналаар зарим өөрчлөлт оруулан 4 бүлэг 35 зүйлтэй хуралдааны дэг баталж, мөрдөн ажиллаж байна.

Мөн тус зөвлөлийн 2014 оны 4 дүгээр улиралд хийх ажлын төлөвлөгөөний төсөл боловсруулан хуралдаанаар хэлэлцүүлж батлан мөрдөн ажиллаа.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлийн 2014 оны 4 дүгээр улирлын ажлын төлөвлөгөөнд 9 асуудал төлөвлөгдж, төлөвлөсөн ажлууд бүрэн биелэгдлээ

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарь батлан мөрдөн ажиллаж байна.

Ажил үүргийн хувиараар Иргэний зөвлөлд хууль, дүрмээр олгогдсон эрх хэмжээний хүрээнд хийгдэх 20 төрлийн ажил үүргийг зөвлөлийн гишүүн тус бүрт хувиарлан харицууллаа.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлийн хуралдааны дэг, 4-р улирлын ажлын төлөвлөгөө, зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг аймгийн ИТХ-ын ажлын алба, Цагдаагийн газарт олшруулан хүргүүлсний дээр зөвлөлийн гишүүдэд тусгайлан хавтсанд хийж өглөө.

Мөн дээрхи баримт бичгүүдийг Аймгийн ИТХ-ын мэдээллийн самбарт тавьж иргэдэд мэдээлэл хүргэлээ.

Иргэний зөвлөлийн гишүүн хүн тус бүрийг тусгайлан хавтастай болгож, хавтсанд нь Цагдаагийн албаны тухай хууль, Цөгдөөгийн алба хаагчийн ёс зүйн дүрэм, Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлийн дүрэм, Иргэний зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарь, Улирлын ажлын төлөвлөгөө зэргийг хийж өглөө.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх иргэний зөвлөл нь Иргэний зөвлөлийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4,1,4,2 дахь заалтыг баримтлан ээлжит хурлыг 2 удаа, ээлжит бус хурлыг ажлын шаардлагаар 2 удаа тус тус хуралдууллаа.

Иргэний зөвлөл хийсэн ажлынхаа талаар аймгийн ИТХ-ын даргад 2014 оны 11 дүгээр сард зөвлөлийн гишүүд бүрэн бүрэлдүүнээрээ орж танилцууллаа. Мөн ажлын алба, зөвлөлийг хариуцсан ажилтанд сар тутам танилцуулж ажилласан болно.

Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21,7 дахь хэсэгт заасныг баримтлаг Олон нийтийн цагдаагийн ажилтны зарим асуудал, тэдний урамшуулал, үнэмлэх, дүрэмт хувтасны талаар Хууль зүйн сайдад албан тоотоор асуудал тавилаа. Хармсалтай нь өнөө болтол ямар нэгэн хариу ирүүлээгүй байна.

Цагдаагийн алба хаагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулж тус байгууллагын хүсэлтийн дагуу “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр 2 цагийн сургалт зохион байгуулан явууллаа.

Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21,6,3 дахь заасан эрхийн хүрээнд Гэмт хэрэг, зөрчлийн талаарх өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шалгах, шийдвэрлэх үйл ажиллагааны талаар иргэдийн санал, хүсэлтийг авах хайрцгийг Цагдаагийн газар дээр байрлуулж ажилууллаа.

Аймгийн цагдаагийн байгууллагын алба хаагч ажилтнуудын боловсрол, ажиллах нөхцөл нийгмийн баталгааны өнөөгийн байдлын талаар зарим судалгааг гаргуулан авлаа.

Цагдаагийн Ерөнхий газраас албан тоотоор хүссэний дагуу Зөвлөлийн гишүүдийн талаарх зарим судалгааг ирүүлсэн албан тоот, хавсралтын дагуу гаргаж хугацаанд нь хүргүүллээ.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөл нь 2015 оны Иргэний зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийн төслийг боловсруулж Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн ИТХ-ын дарга, ажлын албанд 10-р сард хүргүүлсний дээр аймгийн ИТХ-ын Төсөв, саихүү, эдийн засгийн хороонд 2014 оны 12 дугаар сарын 26-нд буюу аймгийн ИТХ-ын хуралдаан болж байсан үеэр хүргүүлсэн билээ.

Гэвч тус зөвлөлийн 2015 оны үйл ажиллагаанд зориулж тодорхой төсөв баталж өгөөгүй болно.

Тус зөвлөл нь 2014 онд хууль, дүрмээр олгогдсон эрх хэмжээний хүрээнд 4 асуудлаар 4 байгууллага, нэгжид 5 албан тоот хүргүүлж 3 албан тоот хүлээн авч харилцаж ажиллаа.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлөөс 2015 онд зохион байгуулж хийх ажлын төлөвлөгөө боловсруулж Иргэний зөвлөлийн 2014 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж баталлаа.

Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газраас ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлийн гишүүдийн чадавхийг сайжруулах сургалтыг Энэ оны 12 дугаар сарын 22-23-нд Ховд аймагт зохион байгуулан явууллаа.

Үг сургалтад манай Иргэний зөвлөлөөс 4 гишүүн оролцож Цагдаагийн албаны тухай шинэ хуулийг хэрэгжүүлэх талаар цагдаагийн байгууллагаас зохиож байгаа ажил, цаашдын бодлого чиглэл, Цагдаагийн байгууллага, Иргэний зөвлөлийн хамтын ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл авлаа.

Мөн Иргэний зөвлөлөөс зохион байгуулж байгаа ажлын талаар харилцан мэдээлэл солилцлоо.

Ховд аймгийн орон нутгийн телевизээд Увс аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлөөс зохион байгуулж байгаа ажил болон сургалтын талаар ярилцлага өглөө.

Аймгийн Цагдаагийн газраас 2014 оны 12 дугаар сарын 26-нд зохион байгуулсан Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлийн гишүүд, Олон нийтийн цагдаагийн ажилтны зөвлөгөөнд Иргэний зөвлөлийн 5 гишүүн оролцлоо.


Уг зөвлөгөөнд Иргэний зөвлөлийн үйл ажиллагааны явц байдлын талаар Иргэний зөвлөлийн дарга Н. Гэжээ товч мэдээлэл хийлээ.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлийн үйл ажиллагааны явц байдлын талаар орон нутгийн МВС болон САМА телевизэд ярилцлага өглөө .

Цаашид тавих санал :

1. Хууль зүйн сайдын 2014 оны А/89 дүгээр тушаалаар баталсан Иргэний зөвлөлийн дүрэмд заасны дагуу Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлийн гишүүдийг аймгийн ИТХ болон Цагдаагийн байгууллагаас зохион байгуулах сургалтад хамруулах талаар анхаарч ажиллах .
2. Цагдаагийн албаны хууль болон зөвлөлийн ажиллах дүрэмд заасны дагуу Иргэний зөвлөлийг зохих хэмжээний төсөвтэй байлгаж. Зөвлөлийн гишүүдэд хууль , дүрэмд заасны дагуу хийсэн ажилд нь тохирсон зохих хэмжээний урамшил олгодог байх.
3. Зэргэлдээх аймгийн Иргэний зөвлөлийн ажлын арга барил туршлагыг судлах ажилтай нь танилцхад дэмжлэг үзүүлэх .
4. Гадаадын аль нэг орны ижил төстэй байгууллагын ажлын арга барил, туршлагыг судлах, хамтын ажиллагаа тогтооход дэмжлэг үзүүлэх.

Тайлан бичсэн Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлийн

ДАРГА 
Н. ГЭЖЭЭ